



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/010/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Б.Наранцэцэг Утас: 7036-3047 Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-22
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-19
4. Аудитын тайлан	19-22
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. Аудитын илрүүлэлт	23-27
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	28-29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
МТТАТ	Малын тоо толгойн албан татвар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



Г ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА Г
Ж.ОТГОНДАЛАЙ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № СА-2026/010/НА-СТА-ТБ

танай _____-ны № _____-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхланта сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд ой хээрийн түймэр, үер, өвөлжилт хүндэрч зуд болсонтой холбоотойгоор Засаг даргын нөөц хөрөнгөөс дээрх гамшгийг арилгахад 26,591.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4326050359

Өмнөх онд тус сумын суурь орлогын дүнд малын тоо толгойн албан татварын орлогыг оруулан тооцож, баталсныг тайлант онд залруулан аймгийн төсвөөс 103,284.6 мянган төгрөгийн санхүүжилтийг нөхөн олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4	357,910.46	566,625.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		124,088.05	216,368.27
33	АВЛАГА		181,111.81	164,158.38
35	БАРАА МАТЕРИАЛ	6	44,800.60	186,098.54
36	НӨӨЦИЙН БАРАА		7,910.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,914,401.71	2,207,745.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	1,914,401.71	2,207,745.12
39200	Биет хөрөнгө		1,910,415.84	2,191,266.42
39300	Биет бус хөрөнгө		3,985.87	16,478.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,272,312.17	2,774,370.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9	-	2,809.48
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-	2,809.48
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,272,312.17	2,771,560.83
51	Засгийн газрын хувь оролцоо		2,272,312.17	2,771,560.83
51100	Засгийн газрын оруулсан капитал		339,508.65	339,508.65
51200	Хуримтлагдсан үр дүн		1,691,506.77	2,190,755.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		241,296.75	241,296.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,272,312.17	2,774,370.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	2,512,458.50	3,152,292.41
11	ТАТВАРЫН ОРЛОГО		553,885.74	552,544.68
110	Орлогын албан татвар		357,539.54	361,184.76
1100	Хувь хүний орлогын албан татвар		386,251.28	404,857.58
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		- 28,711.74	- 43,672.82
113	Хөрөнгийн албан татвар		140,405.85	123,546.05
118	Бусад татвар, төлбөр, хураамж		55,940.35	67,813.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		527,926.12	2,599,747.73
120	Нийтлэг татварын бус орлого		527,926.12	717,019.89
122	Тусламжийн орлого		-	1,571,514.44
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		-	311,213.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,430,646.64	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		11,807.44	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		1,418,839.20	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	1,843,108.47	2,124,052.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,843,108.47	2,124,052.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,789,536.57	2,112,002.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		745,458.00	919,602.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		88,497.85	115,865.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		476,860.72	489,598.77
2104	Хангамж, бараа материалын зардал		58,570.38	51,816.46
2105	Нормативт зардал		36,090.77	93,261.26
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,414.00	8,970.00
2107	Томилолт, зочны зардал		10,650.46	26,319.14
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		364,994.39	406,569.09
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		53,571.91	12,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		669,350.02	1,028,239.46
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		388,088.85	528,990.80
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		- 388,088.85	- 528,990.80
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		281,261.18	499,248.66
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		2,512,458.50	3,152,292.41

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,042,205.17	2,503,053.84
11	ТАТВАРЫН ОРЛОГО	553,885.74	552,544.67
110	Орлогын албан татвар	357,539.54	361,184.75
1100	Хувь хүний орлогын албан татвар	386,251.28	404,857.58
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	- 28,711.74	- 43,672.82
113	Хөрөнгийн албан татвар	140,405.85	123,546.05
118	Бусад татвар, төлбөр, хураамж	55,940.35	67,813.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,672.80	1,950,509.16
120	Нийтлэг татварын бус орлого	57,672.80	67,781.32
122	Тусламжийн орлого	-	1,571,514.44
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	311,213.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,430,646.64	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,631,042.96	1,881,782.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,631,042.96	1,881,782.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,576,971.05	1,869,732.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	744,976.30	919,110.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,626.76	115,865.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	490,525.62	489,598.77
2104	Хангамж, бараа материалын зардал	53,925.39	46,371.88
2105	Нормативт зардал	35,087.63	100,077.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,414.00	8,970.00
2107	Томилолт, зочны зардал	11,311.28	26,319.14
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	143,104.09	163,419.11
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,071.91	12,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	411,162.21	621,271.03
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	394,319.95	528,990.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	394,319.95	528,990.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	- 394,319.95	- 528,990.80
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	100,000.00	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	- 100,000.00	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	- 83,157.73	92,280.23
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	207,245.78	124,088.05
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	124,088.05	216,368.27
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,042,205.17	2,503,053.84

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Данс ны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	339,508.65	241,296.75	1,410,245.60	1,991,050.99
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	339,508.65	241,296.75	1,410,245.60	1,991,050.99
3	Тайлант үеийн үр дүн	-	-	281,261.18	281,261.18
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	339,508.65	241,296.75	1,691,506.77	2,272,312.17
5	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	339,508.65	241,296.75	1,691,506.77	2,272,312.17
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	339,508.65	241,296.75	1,691,506.77	2,272,312.17
7	Тайлант үеийн үр дүн	-	-	499,248.66	499,248.66
8	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	339,508.65	241,296.75	2,190,755.44	2,771,560.83

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Данс-ны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,631,141.60	2,490,008.38	141,133.22	94.6
11	Татварын орлого	676,535.30	552,544.68	123,990.62	81.7
110	Орлогын албан татвар	364,572.50	361,184.76	3,387.74	99.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	408,245.30	404,857.58	3,387.72	99.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(43,672.80)	(43,672.82)	0.02	100.0
113	Хөрөнгийн албан татвар	252,849.80	123,546.05	129,303.75	48.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	59,113.00	67,813.87	(8,700.87)	114.7
12	Татварын бус орлого	1,954,606.30	1,937,463.71	17,142.59	99.1
120	Нийтлэг татварын бус орлого	86,160.00	69,017.41	17,142.59	80.1
122	Тусламжийн орлого	1,868,446.30	1,868,446.30	-	100.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,748,910.40	2,399,155.51	349,754.89	87.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,945,152.10	1,870,164.70	74,987.40	96.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,932,652.10	1,858,114.70	74,537.40	96.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	936,598.20	919,110.26	17,487.94	98.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,428.40	115,865.75	1,562.65	98.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	493,591.10	483,904.47	9,686.63	98.0
2104	Хангамж, бараа материалын зардал	49,859.10	45,615.70	4,243.40	91.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	104,395.50	97,977.90	6,417.60	93.9
2107	Томилолт, зочны зардал	13,260.10	8,970.00	4,290.10	67.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,489.40	25,745.47	22,743.93	53.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	169,030.30	160,925.15	8,105.15	95.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,500.00	12,050.00	450.00	96.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	753,758.30	528,990.80	224,767.50	70.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,000.00	-	50,000.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	124,088.05	(124,088.05)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	216,368.27	(216,368.27)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	55	54	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	26	25	0.00	96.2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	6	6	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	15	14	0.00	93.3

620002	Гүйцэтгэх ажилтан	5	5	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	26	25	0.00	96.2
620004	Гэрээт ажилтан	12	12	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	4	3	0.00	75.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	5	5	0.00	100.0
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	5	5	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2	2	0.00	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	26	25	0.00	96.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
I	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	14,966.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,966.76
122	Тусламжийн орлого	14,966.76
1221	Хандив тусламж /дотоод/	14,966.76
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,966.76
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,135.11
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,831.65
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,618.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,618.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,618.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,694.29
2104	Хангамж, бараа материалын зардал	756.18
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	573.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,493.96
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	3,348.66
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	- 3,348.66
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 3,348.66

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **20,531.3** мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад **1,689.7** мянган төгрөгийн алдааг залруулж, **18,841.6** мянган төгрөгийн алдааг 2026 оны эхний хагас жилд залруулах зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийг иргэний зээлээс 1,689.7 мянган төгрөгөөр илүү хасаж тооцсон буюу ХХС-ийн программд зээлийн авлагын үлдэгдлийг бууруулж тайлагнасан.

Залруулаагүй алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд 2014 онд ашиглалтад орсон нийтийн ариун цэврийн цэгийн ашиглах жилийг буруу тогтоосон буюу НБББББ-т тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааг 10 жилээр тогтоохоор заасан боловч 63 жилээр тооцож, элэгдүүлсэн, 5 нэр төрлийн хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоогоогүйгээс 10,136.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тусгасан,
- Санхүүгийн тайланд иргэн, хоршоодод олгосон зээлийн үлдэгдлийг 1,357.6 мянган төгрөгөөр илүү, зээлийн хүүгийн үлдэгдлийг 10,062.4 мянган төгрөгөөр дутуу тусгасан буюу санхүүгийн тайланг ХХС-ийн программын мэдээллээс 8,704.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:” 14.4.1-д “Аж ахуйн бүх ажил, гүйлгээ;”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь ““Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, байгууллагын НБББББ-ийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа”, УСНББОУС 1: “Санхүүгийн тайлангийн толилуулга” 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой ...”, УСНББОУС 17: “Үндсэн хөрөнгө”-ийн 59-д “Үндсэн хөрөнгийн тухайн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц өртөг бүхий хэсэг бүрийг тусад нь элэгдүүлнэ” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэлт: Элэгдлийн зардлыг дутуу тусгасан, зээлийн болон зээлийн хүүгийн авлагыг зөрүүтэй бүртгэсэн алдааг 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийх зөвлөмж өгөв.

Аудитаар нийт **73,402.0** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **149.0** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **16,767.4** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх **56,486.0** мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **16,916.4** мянган төгрөгийн залруулагдаагүй материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,192.1 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. ЗДТГ-ын дарга Г.Бямбадалайд **149.0** мянган төгрөгийн цалин илүү тооцож, олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. Батлагдсан төсвийг зардлын бүлэг, эдийн засгийн ангилал болон хөтөлбөр хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй **15,440.6** мянган төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЗДТГ:

- Мэдээлэл технологийн үйлчилгээний төлбөрөөс мэргэжлийн үйлчилгээний төлбөрт 6,576.4 мянган төгрөг, багаж, техник хэрэгсэл худалдан авахад 1,571.6 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлаас бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлс худалдан авахад 2,784.9 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардалд 1,144.1 мянган төгрөг, багаж техник, хэрэгсэл худалдан авахад 1,978.6 зэрэг нийт **14,055.6** мянган төгрөг.

ИТХ:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжаас бичиг хэргийн зардалд 100.0 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлаас бичиг хэргийн зардалд 1,000.0 мянган төгрөг,
- Бичиг хэргийн зардлаас бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлс худалдан авахад 285.0 мянган төгрөг зэрэг нийт **1,385.0** мянган төгрөг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь

өмнө хянан, баталгаажуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр бичиг хэргийн материалын **1,326.8** мянган төгрөгийг тайлант оны төсвөөс шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3: “бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Бараа материалын тайлантай холбоотой асуудал:

Илрүүлэлт: ЗДТГ нь бараа материалын дансны ангиллыг мөрдөөгүй, нярвын хариуцсан хөрөнгийг тоолж баталгаажуулдаггүй, ЗДНХ-өөр бэлтгэсэн хивэг, өвсийг жилийн эцэст бөөн дүнгээр зарлагадаж, санхүүгийн тайланд үлдэгдэлгүйгээр тусгасан, шатахууны зарцуулалтад спидометрийн заалтыг тэмдэглэдэггүй зэрэг бүртгэл, тайлагнал хангалтгүй, материалын тайланд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:”, 12.2.1: “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;”, 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Ангилал”, “Тохиолдсон байх”, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу хөтөлж, хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах.

5.3.2. Анхан шатны баримттай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэл дутуугаар нийт **13,198.4** мянган төгрөгийн дараах ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

ЗДТГ:

- Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар засвар үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай эсэх, төсөв тооцоо, судалгаа зэрэг асуудлыг хэлэлцүүлж, дүгнүүлэлгүйгээр автомашины засвар үйлчилгээнд нийт 6,100.5 мянган төгрөгийг зарцуулсан,
- Шаардах хуудас, маршрут зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 2,804.5 мянган төгрөгийн шатахуун зарлагдсан,

ОНХС:

- Магадалшгүй ажлын хурлын тэмдэглэл, төсөв, гүйцэтгэсэн ажлын зураг зэрэг анхан шатны баримтгүйгээр 4 төсөл арга хэмжээнд *Ималын худгийн хашаа, орон нутгийн өмчит байгууламжуудын засвар, ухаалаг худаг, ус цэвэршүүлэх байгууламж, ЕБС-ийн дээврийн засвар*/4,293.4 мянган төгрөгийн магадалшгүй ажлын зардал олгосон.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. ...", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны хүчин төгөлдөр баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3.3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт: ЗДТГ нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 22 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох болон актлах саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох",

УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн ХЗУ²4-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж байгаа хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон актлах эсэх саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

5.3.4. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус ТТЗ-ийн авлага дансны үлдэгдэлд **43,287.6** мянган төгрөгийн дараах авлагууд тайлагнагдсан боловч өнөөг хүртэл барагдуулах арга хэмжээ аваагүй байна. Үүнд:

- ОНЕО-ын дансанд итгэлийн зээлийн 2,293.4 мянган төгрөгийн /эзэн холбогдогч нь тодорхой бус/,
- ХХС-ийн дансанд 2012-2018 онуудад олгосон 6 иргэний хугацаа хэтэрсэн зээлийн 40,994.2 мянган төгрөгийн зэрэг.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 дахь “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² ХЗУ-Хэрэгжүүлэх заавар удирдамж

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	2	10,394.5			2	10,394.5	1	1,689.7	1	8,704.8	1	8,704.8
ЗДТГ	1	10,136.8	1	10,136.8					1	10,136.8	1	10,136.8
Нийт дүн	3	20,531.3	1	10,136.8	2	10,394.5	1	1,689.7	2	18,841.6	2	18,841.6

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	2	47,581.0					2	47,581.0				
ИТХ	1	1,385.0			1	1,385.0						
ЗДТГ	6	24,436.4	1	149.0	2	15,382.4	3	8,905.0				
Дүн	9	73,402.0	1	149.0	3	16,767.4	5	56,486.0				

/мянган төгрөгөөр/

